

ТАНИЛЦУУЛГА

“Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөл боловсруулсан тухай

2024 оны 11 дугаар сарын 25-ны өдөр

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсэгт “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 05-ний өдрийн “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолоор нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмын баталж Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 1/2049 дугаартай албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолыг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсэгт заасан агуулга, хүрээ, зорилгод нийцүүлэн баталж, дахин бүртгүүлэхээр ирүүлэхийг хүссэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсэгт заасан агуулга, хүрээ, зорилгод нийцүүлэн “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг боловсруулав.

Энэхүү тогтоолоор даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, гарааны үлдэгдэл тооцох, ажил олгогч, даатгуулагчийн тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлийг бүртгэх, нэрийн дансанд тооцсон хүүг бүртгэх, нэрийн дансанд бүртгэсэн орлогын бодит мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хэсгийг бүртгэх, хяналт, хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

---oOo---